



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

13330 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
13 дугаар хороо, 14 дүгээр хороолол,
Энхтайваны өргөн чөлөө-57
Утас: 26-31-60, Факс: (976-11) 45-82-54
<http://www.bzd.ub.gov.mn>

2019.05.22 № 014/332
танай _____-ны № _____-т

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХАРЬЯА
ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАРТ**


Дүүргийн нутаг дэвсгэрт Зуслан ногоон бүсийн их цэвэрлэгээг 2019 оны 05 дугаар сарын 25-ны Бямба гаригт зохион байгуулна.

Иймд цэвэрлэгээнд ажилтан албан хаагчдыг идэвхтэй оролцуулж, тайлан мэдээг 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 15 цагаас өмнө bzd.dedbutets@gmail.com цахим хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт 7 хуудастай.

ДЭД БҮТЭЦ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛИЙН
УДИРДАГЧ-ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Т.БАТЦОГТ



1130200228



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

**Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээ
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай А/285 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдах бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг шинэчлэн батлах тухай А/130 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Зуслан, ногоон бүс, байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хог хаягдлаас үүдэлтэй хөрс, усны бохирдол, халдварт өвчний тархалтаас сэргийлэх зорилгоор Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээг 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсугай.

2. Их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хяналт тавьж ажиллах удирдамжийг хоёрдугаар, цэвэрлэгээ хийх зурган маршрутыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албад, Засаг даргын Тамгын газрын дэргэдэх харьяа хэлтэс, албад, 28 хорооны ажилтан албан хаагчдыг оролцуулж, хяналт тавьж ажиллахыг Төхижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /Б.Отгонхүү/, Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн Төрийн бус байгууллага /А.Нямдорж/ нарт тус тус даалгасугай.

4. Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээнд Иргэдийн бүлэг, зам талбайн үйлчлэгчдийг идэвхтэй оролцуулж, өнжмөл шар өвсийг цэвэрлэх, цэвэрлэгээнээс гаргасан хог хаягдлыг уртасгасан цагаар тээвэрлэхийг Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ /Ж.Мөнх-Од, Д.Нэргүй, Х.Өлзийхорол, Э.Хатанбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

5. Цэвэрлэгээний ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг Хэвлэл мэдээллийн албанд даалгасугай.

6. Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч /Т.Батцогт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ

1130200883

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2019 оны 1 дугаар сарын 12 ны
өдрийн 2 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

ЗУСЛАН, НОГООН БҮСИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Т.Батцогт

Дэд бүтэц, хот төлөвлөлтийн
асуудал хариуцсан төслийн
удирдагч Засаг даргын орлогч

Гишүүд:

Б.Амартүвшин

Засаг даргын Тамгын газрын дарга

Т.Амартогтох

Баянзүрх дүүргийн Цэргийн
штатсын дарга, хошууч

Ж.Батжавхлан

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга

Ц.Өсөхбаяр

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Санхүү төрийн
сангийн хэлтсийн дарга

С.Сувд-Эрдэнэ

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн дарга

О.Ариунболд

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Хүнс, худалдаа
үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Отгонхүү

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Тохжилт, нийтийн
аж ахуйн хэлтсийн дарга

П.Сумьяасүрэн

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Төлөвлөлт,
гүйцэтгэлийн хяналт
шинжилгээний хэлтсийн дарга

Т.Соёл-Эрдэнэ

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Хэвлэл мэдээлэл,
олон нийттэй харилцах асуудал
хариуцсан мэргэжилтэн

Ж.Мөнх-Од
Баянзүрх дүүргийн Нийтлэг
үйлчилгээний газар-1 ОНӨААТҮГ-
ын дарга

Д.Нэргүй
Баянзүрх дүүргийн Нийтлэг
үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ-
ын дарга

Х.Өлзийхорол
Баянзүрх дүүргийн Нийтлэг
үйлчилгээний газар-3 ОНӨААТҮГ-
ын дарга

Э.Хатанбаатар
Баянзүрх дүүргийн Нийтлэг
үйлчилгээний газар-4 ОНӨААТҮГ-
ын дарга

А.Нямдорж
Эрүүл мэнд, нийгмийн бодлогын
хүрээлэн ТББ-ын тэргүүн

Хороодын Засаг дарга нар

А.Монголжингоо
Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Тохижолт, нийтийн
аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2019 оны 05 дугаар сарын 25-ны
өдрийн 05 дугаар захирамжийн
87198 2 дугаар кавсралт

**ЗУСЛАН, НОГООН БҮСИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНД
ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

Зорилго: Ногоон бүсийн оршин суугчдын ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хог хаягдлаас үүдэлтэй хөрс, усны бохирдол, халдварт өвчний тархалтаас сэргийлэх зорилгоор Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулна

Хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр /11:00 цагаас/

Ажил үүргийн хуваарь:

№	Цэвэрлэгээ хийх байршил	Хяналт тавих хэлтэс
1	2	3
1	20 дугаар хороо, Хэр усан тохойгоос Маршлын гүүр хүртэл	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
2	Сэлбэ гол дагуу	Санхүү, төрийн сангийн хэлтэс
3	Улиастайн гол дагуу	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

Хийгдэх ажлын чиглэл:

1 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63, 2012 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам"-ын хэрэгжилтийг хангуулах, олон нийтэд сурталчлах;

2. Хороод хог хаягдлын үйлчилгээ үзүүлж буй Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай хамтран ажиллаж, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, оршин суугчид Их дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, цэцэрлэгийн албан хаагчдад цэвэрлэгээний талаарх мэдээллийг шуурхай хүргэж, их цэвэрлэгээний ажилд идэвхтэй татан оролцуулах;

3. Цэвэрлэгээнд оролцоогүй аж ахуйн нэгж байгууллагын хамсаалтыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст ирүүлэх;

4 Их цэвэрлэгээнд шаардлагатай багаж, хэрэгслийг өөрсдөө бэлтгэн оролцоно

Цэвэрлэгээний ажилд хяналт тавих:

Бүх нийтийн их цэвэрлэгээнд Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

Цэвэрлэгээний ажлыг сурталчлах:

Бүх нийтийн их цэвэрлэгээг иргэдэд зарлах, сурталчлах ажлын явц байдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр сурталчлан ажиллана.

Ажлын дүнг гаргах:

Хороодод болон Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь цэвэрлэгээ хийсэн тайлан мэдээг цэвэрлэгээ хийсэн өдрийн 15 цагаас өмнө фото зургаар /цэвэрлэгээний өмнөх болон дараах гэсэн харьцуулалттай/ баталгаажуулан, файлаар хүснэгтэн мэдээллийн хамт bzd.dedbutets@gmail.com цахим хаягаар ирүүлэх бөгөөд нэгдсэн дүн мэдээг Нийслэлийн Шуурхай Удирдлага Зохицуулалтын төв болон Захирагчийн ажлын албанд хүргүүлнэ. Мэдээг хоцроосон, худал мэдээлэл ирүүлсэн байгууллагыг бүх нийтийн их цэвэрлэгээг хангалтгүй зохион байгуулсанд тооцно. Идэвхгүй оролцсон хороод, аж ахуйн нэгж, байгууллагад Хөг хаягдлын тухай хуульд заасан арга хэмжээг авна.

Жич: Хяналт тавих хэлтсүүд нь хариуцсан хороодтой хамтран ажиллах, цэвэрлэгээний явц байдлын талаар илтгэх хуудас ирүүлэх.

Утас 51-266579, 99278448 А.Монголжингоо;


Дүүргийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 20-ны өдрийн
1499 захирамжийн 3 дугаар хэвсрэлт

ЗУСЛАН, НОГООН БҮСИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАРШРУТ



Цугларах газар: 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 09 цаг 40 минутад, Туулын гүүрний баруун хойд хэсэгт байрлах Адам Ева хөшөөний урд талд цугларах;

Цэвэрлэх талбайн байршил: Туул голын гүүрнээс Төмөр замын гүүр хүртэл голын хойд хэсэг;



Цугларах газар: 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 09 цаг 40 минутад, Туулын гүүрний баруун хойд хэсэгт байрлах Адам Ева хөшөөний урд талд цугларах;

Цэвэрлэх талбайн байршил: 20, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах цэвэр ундны усны хамгаалалтын зурвас газар,